



**ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ СЕМИНАР-2014**

Улаанбаатар 2014

**“ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ СЕМИНАР-2014”
ХӨТӨЛБӨР**

Зорилго: Ой, хээрийн түймрээс хамгаалах талаар төрийн зохицуулалтын үр нөлөөт байдлыг дээшлүүлэх, талуудын оролцоог хангах

Нээлтийн үг: БОНХЯ-ны дэд сайд, Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн дарга Б.Тулга

“Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах үндэсний семинар-2014” сэдэвт энэхүү арга хэмжээг өвлийн улирлын төгсгөл, хаврын хуурайшилт эхэлж, манай орны ой, хээрийн экосистемд гал түймрийн аюулын зэрэг ихсэхээс өмнө зохион байгуулж байна.

Цаг агаарын хуурайшилт, хуримтлагдсан хагд өвс, хүмүүсийн хайхрамжгүй аливаа үйл ажиллагаа зэрэг нь улсын хэмжээнд ой, хээрийн түймрийн тоо, тархалтыг нэмэгдүүлэх үндсэн гурван хүчин болж байна.

Сүүлийн жилүүдэд манай оронд гарсан ой, хээрийн түймэрт олон мянган га ойн баялаг, бэлчээрийн чухал ач холбогдол бүхий газар нутгууд өртөн байгаль, экологийн асар их хохирол учирсаар байгаа төдийгүй иргэдийн аж амьдралд түймрийн үзүүлж буй сөрөг нөлөөлөл улам ихэссээр байна.

Түүнчлэн өнгөрсөн жилүүдийн түймэрт хүний ам эрсдэж, иргэдийн гэр орон шатаж, олон зуун тооны мал хорогдож, малын өвөлжөө, хаваржаа шатсанаар иргэдийн аж амьдралд эдийн засгийн асар их дарамтыг учруулаад байна. Ой, хээрийн түймрийн утаа хөдөө орон нутгийн суурин газрууд төдийгүй Улаанбаатар хотыг удаан хугацааны туршид бүрхснээр иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг ба ялангуяа өндөр настан, хүүхэд, амьсгалын замын өвчтэй хүмүүс хамгийн ихээр өртдөгийг бид мэдэх билээ.

Бүс нутаг, цаашлаад дэлхийн уур амьсгалын өөрчлөлт Монгол оронд нөлөөлж, цаг агаарын аюулт үзэгдэлд тооцогдох зуд, цасан шуурга, шороон шуурганы давтамж, хамрах хүрээ нэмэгдсээр байна. Эдгээр байгалийн үзэгдлээс сэргийлэх боломж тун бага бөгөөд ой хээрийн түймрийн байгальд учруулж буй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломжтой юм. Учир нь манай орны түймрийн ихэнх нь хүний үйл буруутай ажиллагаанаас үүдэлтэй тул маш няхуур менежментийн төлөвлөлт, хүний үйл ажиллагаанд чиглэсэн арга хэмжээ авснаар байгалийн баялгийн хорогдолт, цөлжилтийг бууруулах боломжтой юм.

Зургаан жилийн өмнө “Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөл” анх байгуулагдаж байсан юм. 2008 онд “Төв Азийн бүс нутгийн байгалийн түймрийн экологи, менежмент” сэдэвт олон улсын хурал Монгол улсад анх удаа зохион байгуулагдаж, тухайн бүс нутгийн байгалийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийн тулгамдсан асуудлууд, хэрэгжүүлж буй бодлогын талаар авч хэлэлцсэн юм. Энэхүү хурлын дараа тухайн онд Монгол орны ой, хээрийн түймэртэй холбоотой асуудлыг хариуцдаг бүх байгууллагуудын төлөөлөл оролцсон үндэсний зөвлөлгөөн зохиогдож, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын хамтарсан тушаалаар тус Зөвлөлийг 2009 онд баталсан юм.

Зөвлөл байгуулагдсанаас хэдхэн долоо хоногийн дараа тухайн үеийн Шадар сайд М.Энхболд Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо зохион байгуулагдсан Гамшгийн эрсдлийг бууруулах дэлхийн хоёрдугаар чуулганд оролцон, дэлхийн улс орнуудад Монгол улсын Засгийн газраас Гамшгийг бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон “Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөл”-ийг байгуулж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж байгаа талаар танилцуулсан юм.

2009 онд уг Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө (Ойн түймрийн тогтвортой менежмент)-г баталсан цагаас эхлэн тухайн үеийн Ойн агентлаг, Онцгой байдлын ерөнхий газар, Цаг уурын хүрээлэн, Улсын мэргэжлийн хяналтын газар, Мөрдөн байцаах газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг олон байгууллагууд хамтран түймрийн менежментийн үндэсний чадавхийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Зөвлөлд багтаж буй байгууллагууд аль болох орон нутгийн түвшинд анхаарч үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаа юм. Бид орон нутгийн иргэдийг ой, хээрийн түймрээс сэргийлэх, ялангуяа гал түймэр дөнгөж гарч эхэлж буй шатанд газар авахуулалгүй унтраах чадавхийг бий болгох нь чухал юм.

Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн “Ой, хээрийн түймрийн менежментийг сайжруулах үндэсний семинар-2014” сэдэвт энэхүү хурлаар гишүүн байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний өнөөгийн байдалтай танилцаж, харилцан мэдээлэл, туршлага солилцохыг зорьж байна. Түүнчлэн бид монгол орны ой, хээрийн түймрийн менежментийг сайжруулах талаар хамтарч хийх ажлын төлөвлөгөөгөө батлаж гаргах юм. Өнөөдөр “Олон улсын ойн өдөр” тохиож байна. Ойн доройтлоос сэргийлэх, түүнийг бууруулах замаар тогтвортой амьжиргааг тэтгэх энэхүү тэмдэглэлт өдрийн гол үзэл санаатай бидний өнөөдрийн үйл ажиллагаа давхцаж байна. Хөрш зэргэлдээ ОХУ-д гарсан түймэр, түүний утаа хил дамнан манай улсын нутаг дэвсгэрт шилжих, мөн манай талаас хөрш улсын хилээр түймэр давах байдал нь бидэнд хөрш улс орнуудтайгаа нягт хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл, туршлага, мөн мэргэжилтнүүд солилцох, хамтдаа гамшгийн шинж чанартай томоохон түймэртэй тэмцэх шаардлагыг бий болгож байна. Манай яамны Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтэс, Дэлхийн түймрийн мониторингийн төв (ДТМТ), манай Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, ОБЕГ-ын зарим мэргэжилтнүүд, Хууль хэрэгжүүлэхийн их сургууль болон ОХУ-ын зарим мэргэжилтнүүд нар хамтран “Түймрийн менежментийн нэр томъёоны англи-монгол-орос толь бичиг” номыг хэвлүүлэн гаргасан юм. Энэхүү толь бичгийг боловсруулж, олны хүртээл болгоход эдгээр мэргэжилтнүүд 2 жил шахуу хугацаанд хамтран ажилласан бөгөөд манай орны мэргэжилтнүүд олон улсын түймрийн менежментийн талаарх ном зохиолыг уншихад дөхөм болж, хөрш зэргэлдээ орны мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахад гүүр болох нь дамжиггүй.

Семинарын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Мэндчилгээ: Дэлхийн түймрийн мониторингийн төв (ДТМТ)-ийн захирал
Проф. Др. Йоханн Георг Голдаммер**

Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулах үндэсний семинар-2014” сэдэвт энэхүү хурал нь Монгол орны түймрийн менежментийн байгууллагуудын хамтын ажиллагааг ирэх 2 жилд шинэ үе шатанд гаргах чухал үйл ажиллагаа болж байна.

“Төв Азийн бүс нутгийн байгалийн түймрийн экологи, менежмент” сэдэвт олон улсын хурал Дэлхийн түймрийн мониторингийн төв (ДТМТ), Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол улсад анх удаа зохион байгуулагдсан тэр үеэс ДТМТ нь Төв азийн бүс нутаг дахь үйл ажиллагаагаа өргөжүүлж эхэлсэн юм. Монголын судлаачид “Хил дамнасан түймрийн олон улсын хурал” (ОХУ, Эрхүү, 2010), “Олон улсын түймрийн менежментийн 7 хоног” (ОХУ, Красноярск, 2012, 2013), “Уур амьсгалын өөрчлөлт ба ойн түймрийн олон улсын конгресс, үзэсгэлэн худалдаа: Евразийн бүсийн байгалийн болон соёлын өв бүхий газар нутаг дахь түймрийн менежментийн тулгамдсан асуудлууд” (ОХУ, Новосибирск, 2013) зэрэг олон улсын хурлуудад оролцсон. Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн нарийн бичиг, НҮБ-ын Гамшгийг бууруулах олон улсын хөтөлбөрийн Төв Азийн бүс нутгийн түймрийн сүлжээний зохицуулагч бүс нутгаа төлөөлөн Швейцарийн Холбооны Улсын Женев хот дахь НҮБ-ын төвд зохион байгуулагдсан “НҮБ-ын Европын эдийн засгийн комисс (ЕЭЗК)-ын гишүүн улсууд / ХХААБ Хил дамнасан түймрийн менежментийн бүсийн форум” (Швейцарь, Женев, 2013)-д оролцсон нь чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Энэхүү Форумыг Монгол улс 2012 онд 57 дахь гишүүнээр нь элссэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) хамтран ивээн тэтгэж зохион байгуулсан юм. ЕАБХАБ нь ДТМТ-тэй гамшгийг бууруулах салбарт зүүн Европ, Кавказ, Төв Азийн бүс нутагт нягт хамтын ажиллагаатай байдаг юм.

ДТМТ нь удахгүй Улаанбаатар хотноо байгуулагдах Төв Азийн бүсийн түймрийн менежментийн нөөцийн төв (ТАБТМНТ)-өөр дамжуулан Монгол орон болон Төв азийн бусад орнуудын түймрийн менежментийн чадавхийг нэмэгдүүлэх, бодлогыг сайжруулахад дэмжлэгээ үргэлжлүүлэн, хамтран ажилласаар байх болно.

Семинарын үйл ажиллагаанд амжилт хүсье.

**“ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ СЕМИНАР-2014”
ХӨТӨЛБӨР**

Хугацаа	2014 оны 03 сарын 21	Илтгэгч
09:30 – 10:00	Оролцогчдыг бүртгэх	
Семинарыг БОНХЯ-ны дэд сайд, Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн дарга Б.Тулга удирдана.		
10:00 – 10:05	Нээж үг хэлэх: БОНХЯ-ны дэд сайд Б.Тулга	
10:05 – 10:10	Олон улсын ойн өдөрт зориулсан мэндчилгээ	НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн орлогч, ноён Шейх Ахадузамман
10:10 – 10:25	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг сайжруулах менежментийн зарим асуудлууд	БОНХЯ-ны Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн доктор Ц.Чулуунбаатар
10:25 – 10:40	Ой, хээрийн түймэр унтраах, тэмцэх ажлын өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга замууд	ОБЕГ-ын ГТТГ-ын дарга, үндэсний зөвлөлийн гишүүн С.Залуухүү
10:40 – 10:55	Байгалийн түймрийн судалгаа-шинжилгээний ажлын чиглэл, үр дүнгийн тухай товч мэдээлэл	ОБЕГ-ын Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал Б.Баяржаргал
10:55 – 11:10	Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох асуудалд	БОНХЯ-ы Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин
11:10 – 11:25	Түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийн илрүүлэлт, хэрэг бүрдэлтийн тухай асуудал	Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, үндэсний зөвлөлийн гишүүн С.Баянмөнх
11:25 – 11:40	Улсын хилийн дагуух бүс нутгийг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудал	ХХЕГ-ын Хилийн хэлтсийн дарга, үндэсний зөвлөлийн гишүүн, хурандаа Х.Дамдинсүрэн
11:40 – 11:55	Монгол орны ой, хээрийн түймрийн менежментийн үйл ажиллагаанд Төв азийн бүсийн түймрийн менежментийн нөөцийн төв (ТАБТМНТ)-ийн гүйцэтгэх үүрэг (2014-2016 ажлын төлөвлөгөө)	Дэлхийн түймрийн мониторингийн төв (ДТМТ)-ийн Монгол, Төв ази дахь суурин төлөөлөгч, үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, доктор Б.Оюунсанаа

11:55 – 12:25	Асуулт, хариулт	
12:25 – 13:25	Өдрийн хоол	
13:25 – 13:40	Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах ажилд мэргэжлийн хяналтын байгууллагын оролцоо	МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга, үндэсний зөвлөлийн гишүүн Н.Батбаяр
13:40 – 14:10	Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгуудын Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зохион байгуулалт, тулгамдаж буй асуудлууд (аймаг тус бүрээр 10 минутын мэдээлэл хийх)	Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгийн түймрээс хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар
14:10 – 15:10	Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Хөвсгөл, Архангай аймгууд болон Улаанбаатар хотын Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зохион байгуулалт, тулгамдаж буй асуудлууд (аймаг, нийслэл тус бүрээр 10 минутын мэдээлэл хийх)	Төв, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Архангай аймаг болон Улаанбаатар хотын түймрээс хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар
15:10 – 15:25	Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн 2014-2016 онд хийх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн танилцуулга	Дэлхийн түймрийн мониторингийн төв (ДТМТ)-ийн Монгол, Төв ази дахь суурин төлөөлөгч, үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, доктор Б.Оюунсанаа
15:25 – 15:55	Асуулт, хариулт	
15:55 – 16:15	Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний зөвлөлийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх, батлах	Бүх оролцогчид
16:15 – 16:45	Дэлхийн ойн өдөрт зориулсан арга хэмжээ	БОНХЯ-ы Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтэс
	НҮБ-ын ХХААБ-аас Монгол орны ойн салбарт хийж байгаа ажлын тухай товч мэдээлэл	НҮБ, ХААБ-ын Монгол дахь шадар суурин төлөөлөгч, Г. Нямжаргал
16:45 – 17:15	Санал, дүгнэлт, хаалт	Модератор

Семинарыг 2014 оны 03-р сарын 21-ны өдөр Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хурлын “ХААН” танхимд зохион байгуулна.

БОНХЯ-ны Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтэс